

Translated from Mongolian to English

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт
Annex 2 to the Resolution №16
of the Board of Directors dated 18th March 2025.
Sealed by the stamp /Mongolian Stock Exchange/

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ
ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ
REGULATION ON EXCHANGE TRADE SETTLEMENT OF
“MONGOLIAN STOCK EXCHANGE” JOINT STOCK COMPANY’S
MINERAL COMMODITIES
/Шинэчилсэн найруулга/
/Revised Edition/**



**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ
ЖУРАМ**
REGULATION ON EXCHANGE TRADE SETTLEMENT OF THE MINERAL COMMODITIES

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ/ ONE. GENERAL PROVISIONS.....	2
ХОЁР.АРИЛЖААНЫ ТӨЛБӨР, ТООЦОО/ TWO. SETTLEMENT OF EXCHANGE TRADING....	2
ГУРАВ. ХУДАЛДАН АВАГЧИЙН БАЙРШУУЛАХ ДЭНЧИН/ THREE. COLLATERAL TO BE DEPOSITED BY THE BIDDER.....	3
ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ/ FOUR. TRADING FEE	6
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА/ FIVE. RISK MANAGEMENT	6

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам
Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities

Dynamic translation center
Tel: 976-95904858
Email: dynamictranslation123@gmail.com



Хуудас 1

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт
Annex 2 to the Resolution №16
of the Board of Directors dated 18th March 2025.

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ
ЖУРАМ**
**REGULATION ON EXCHANGE TRADE SETTLEMENT OF
“MONGOLIAN STOCK EXCHANGE” JOINT STOCK COMPANY’S MINERAL COMMODITIES**

**НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ONE. GENERAL PROVISIONS**

- 1.1. Энэхүү Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам (цаашид “журам” гэх)-аар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн уул уурхайн бүтээгдэхүүний спот, форвард гэрээний арилжааны төлбөр, тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.1. This “Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities” (hereinafter referred to as the “Regulation”) shall govern the relations related to the settlement of spot and forward agreement trading of mineral commodities on the “Mongolian Stock Exchange” JSC (hereinafter referred to as the “Exchange”).
- 1.2. Уул уурхайн бүтээгдэхүүнд суурилсан фьючерс, опцион, санхүүгийн хэрэгслийн төлбөр, тооцооны үйл ажиллагааг энэ журмаар зохицуулахгүй.
- 1.2. This Regulation does not apply to settlement operations related to futures, options, or financial instruments based on mineral commodities.
- 1.3. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан бусад журам, заавраар зохицуулна.
- 1.3. Relations not regulated by this Regulation shall be governed by Mongolian Civil Code, the Law of Mongolia on Mining Products Exchange, the Law of Mongolia on Company, the Law of Mongolia on the Securities Market, other relevant laws and resolutions, and the regulations and guidelines approved by the Financial Regulatory Commission (hereinafter referred to as the “Commission”) and the Exchange.
- 1.4. Энэхүү журмыг Бирж, Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.
- 1.4. This Regulation shall be followed by the Exchange, trading participants of the Exchange, and other market participants.
- 1.5. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн дэнчин, арилжааны шимтгэл, бүртгэх үйлчилгээний хөлстэй холбоотой төлбөр тооцоог Бирж өөрөө арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэнэ.
- 1.5. The Exchange shall carry out the settlement of payments related to the collateral, trading fees, and registration service fees of the Mineral Commodities Exchange through the commercial bank.

**ХОЁР.АРИЛЖААНЫ ТӨЛБӨР, ТООЦОО
TWO. SETTLEMENT OF EXCHANGE TRADING**

- 2.1. Биржийн арилжааны гэрээний үнийн дүн нь системд хийгдсэн хэлцлийн нийт үнийн

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам
Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities



дүнгээр, арилжааны валют нь зард тусгагдсан валютаар тодорхойлогдоно.

- 2.1. The agreement value of the Exchange trade shall be determined based on the total Implied agreement value executed in the system, and the trading currency shall be defined as the currency specified in the trading announcement.
- 2.2. Энэхүү журмын Гуравдугаар бүлэгт заасны дагуу Худалдан авагч нь дэнчинг байршуулсны үндсэн дээр Биржийн арилжаанд оролцоно.
- 2.2. In accordance with Chapter Three of this Regulation, the bidder shall participate in the Exchange trading only after depositing the collateral.
- 2.3. Гэрээний үнэ, дэнчин, арилжааны шимтгэлийг гадаад валютаар илэрхийлж болно.
- 2.3. The agreement price, collateral, and trading fee may be denominated in foreign currency.
- 2.4. Энэхүү журмын 2.3-т заасан валют (ам.доллар, юань)-ыг худалдагч тодорхойлно.
- 2.4. The foreign currency (USD, CNY) specified in Clause 2.3 of this Regulation shall be determined by the seller.
- 2.5. Биржийн бүртгэх үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэл нь журмын Хавсралт 1-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно.
- 2.5. The registration service fee and the trading fee of the Exchange shall be determined in accordance with the rates specified in Annex 1 of this Regulation.

ГУРАВ. ХУДАЛДАН АВАГЧИЙН БАЙРШУУЛАХ ДЭНЧИН THREE. COLLATERAL TO BE DEPOSITED BY THE BIDDER

ХУДАЛДАН АВАГЧ ДЭНЧИН БАЙРШУУЛАХ COLLATERAL DEPOSIT BY THE BIDDER

- 3.1. Худалдан авагчийн байршуулах дэнчингийн хэмжээ нь спот, форвард арилжааны хувьд уул уурхайн бүтээгдэхүүний доод үнээр илэрхийлсэн худалдах захиалгын нийт үнийн дүнгийн 10 хувь, брокероор дамжуулан арилжаанд оролцох тохиолдолд 5 хувьтай тэнцүү байна.
- 3.1. The amount of collateral to be deposited by the bidder shall be equivalent to 10% of the total value of the selling order based on the minimum price of the mineral commodity in the case of spot and forward trades. If participating through a broker, the collateral shall be 5%.
- 3.2. Худалдан авагч нь арилжаа эхлэхээс буюу бүртгэлийн үе эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө энэ журмын 3.1-т тодорхойлсон дэнчинг Биржийн тусгайлан нээсэн дансанд байршуулсан байна. Тус хугацааг хэтрүүлсэн тохиолдолд арилжаанд оролцуулахгүй.
- 3.2. The bidder must deposit the collateral specified in Clause 3.1 into the Exchange's designated account no later than 30 minutes before the commencement of the trading or registration period. Participation will be denied if this deadline is not met.
- 3.3. Дэнчинг байршуулахдаа худалдан авагч эсхүл түүний брокер нь арилжааны банкин дахь өөрийн нэрийн данснаас шилжүүлэх бөгөөд гүйлгээний утга хэсэгт Биржийн арилжааны систем дэх компанийн бүртгэлийн дугаар, компанийн оноосон нэр, дэнчингийн зориулалтыг тусгасан байна.
- 3.3. When depositing the collateral, the bidder or their broker shall transfer the amount from an account under their name at a commercial bank. The transaction note must indicate the bidder's registration number in the Exchange's trading system, the company's designated name, and the purpose of the collateral.
- 3.4. Хэрэв худалдан авагч, түүний брокероос бусад гуравдагч этгээдийн данснаас дэнчинг шилжүүлсэн тохиолдолд дэнчинг байршуулсан гэж үзэхгүй. Тухайн мөнгийг

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам
Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities



шилжүүлсэн дансанд анх орж ирсэн валютаар, банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр буцаан шилжүүлнэ.

- 3.4. If the collateral is transferred from an account belonging to a third party other than the bidder or their broker, the deposit shall be deemed invalid. The amount, after subtracting the bank transaction fees will be transferred back to the original account in the currency in which it was received.

ХУДАЛДАН АВАГЧИЙН БАЙРШУУЛСАН ДЭНЧИНГЭЭР БАТАЛГААЖИХ ҮҮРЭГ OBLIGATIONS SECURED BY THE BIDDER'S COLLATERAL

- 3.5. Худалдан авагчаар шалгарсан этгээдийн энэ журмын 3.1-т заасны дагуу Биржийн дансанд байршуулсан дэнчин нь биржийн арилжаатай холбоотой дараах үүргийг баталгаажуулна. Үүнд:
- 3.5. The collateral deposited into the Exchange's account in accordance with Clause 3.1 by the successful bidder shall serve as security for the fulfillment of the following obligations related to the exchange trading:
- 3.5.1. Биржийн арилжаанд оролцож худалдан авагчаар шалгарсан тохиолдолд Биржийн арилжааны шимтгэл төлөх үүрэг;
- 3.5.1. The obligation to pay the exchange trading fee upon being selected as the successful bidder;
- 3.5.2. арилжааны гэрээг системд хийгдсэн хэлцлийн дагуу арилжаа дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор бичгээр байгуулах үүрэг;
- 3.5.2. The obligation to execute the trading agreement in writing, based on the terms of the Implied agreement concluded in the system, within 5 working days after the completion of the trade;
- 3.5.3. арилжааны гэрээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэг;
- 3.5.3. The obligation to pay the amount stipulated in the trading agreement within the agreed timeframe;
- 3.5.4. арилжааны гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээн авах үүрэг.
- 3.5.4. The obligation to receive the commodities within the period specified in the trading agreement.
- 3.6. Арилжаанд шалгарсан худалдан авагчийн дэнчинг арилжааны гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд битүүмжилнэ. Энэ тохиолдолд бусад арилжааны дэнчинд тооцуулах зорилгоор ашиглахгүй.
- 3.6. The collateral of the successful bidder shall be held in escrow until full performance of the obligations under the trading agreement. During this time, the collateral can not be used as part of other trades.
- 3.7. Бирж нь 3.5.1-т заасан үүргийг тэргүүн ээлжид хангуулж арилжааны шимтгэлийг дэнчингээс суутгана.
- 3.7. The Exchange shall prioritize the enforcement of the obligation specified in Clause 3.5.1 and deduct the exchange trading fee directly from the collateral.

ДЭНЧИН БУЦААХ, БАТАЛГААЖУУЛАХ COLLATERAL REFUND AND VALIDATION

- 3.8. Арилжаанд худалдан авагч үнийн санал ирүүлээгүй, худалдан авагч нь тухайн арилжаанд оролцоогүй эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд худалдан авагч нь дэнчин буцаан авах хүсэлтээ эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан, дэнчин шилжүүлсэн төлбөрийн баримтын хамт цахим системээр ирүүлнэ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам
Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities

- 3.8. In the event that a bidder does not submit a price offer, does not participate in the trade, or participates but is not selected, the bidder shall submit a request for a collateral refund through the electronic system, accompanied by proof of the initial transfer and a formal letter bearing the authorized person's signature and the official seal.
- 3.9. Бирж нь энэхүү журмын 3.8-д заасан шаардлага хангасан дэнчинг буцаан авах хүсэлтийг үндэслэн ажлын 5 өдрийн дотор, худалдан авагчийн дэнчинг шилжүүлсэн дансанд, анх орж ирсэн валютаар, банкны гүйлгээний шимтгэл хассан дүнгээр буцаан шилжүүлнэ.
- 3.9. Based on a valid request as specified in Clause 3.8, the Exchange shall refund the collateral within 5 working days to the account from which the collateral was originally transferred, in the original currency, after deducting applicable bank transaction fees.
- 3.10. Худалдан авагч дэнчин буцаах хүсэлтийг системээр ирүүлээгүй бол дэнчинг дараагийн арилжаанд оролцох зорилгоор Биржийн дансанд хэвээр үлдээсэнд тооцно.
- 3.10. If the bidder does not submit a request for collateral refund via the system, the Exchange shall consider the collateral as retained for participation in subsequent trades.
- 3.11. Худалдан авагч нь 3.5.2 - 3.5.4-т заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр (хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, төрийн эрх бүхий байгууллагын хориг, хязгаарлалтыг ойлгох ба энэ нь эрх бүхий байгууллагын гэрчилгээ, тодорхойлолтоор нотлогдсон байна) биелүүлээгүй бол Бирж дэнчинг худалдагчид ажлын 5 өдрийн дотор шилжүүлнэ.
- 3.11. If the bidder fails to fulfill the obligations stated in Clauses from 3.5.2 to 3.5.4 without a justifiable reason ("justifiable reason" refers to force majeure events or restrictions imposed by competent state authorities, substantiated by official certificates or notices from those authorities), the Exchange shall transfer the collateral to the seller within 5 working days.

АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ БҮРЭН БИЕЛЭГДСЭНИЙ ДАРАА ДЭНЧИНГ ШИЛЖҮҮЛЭХ

COLLATERAL TRANSFER AFTER FULL PERFORMANCE OF THE AGREEMENT OBLIGATIONS

- 3.12. Худалдагч нь талуудын гэрээ дүгнэсэн акт, гэрээний төлбөрийг бүрэн төлсөн баримт, дэнчин хүлээн авах нэхэмжлэхийг Биржид ирүүлнэ.
- 3.12. The seller shall submit the Agreement Closure Act, proof of full payment under the agreement, and a collateral request invoice to the Exchange.
- 3.13. Худалдагч нь журмын 3.12-т заасан баримтуудыг ирүүлсний дараа Бирж нь дэнчинг ажлын 5 өдрийн дотор худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 3.13. Upon receipt of the documents specified in Clause 3.12, the Exchange shall transfer the collateral to the seller's account within 5 working days.
- 3.14. Хэрэв талууд гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй буюу талуудын хооронд арилжааны гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд тухайн маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүх, арбитрын журмаар эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд Бирж дэнчинг аль нэг тал руу шилжүүлэхгүй.
- 3.14. If the parties have not executed a Agreement Closure Act or if a dispute arises between the parties regarding the trading agreement, the matter shall first be resolved through amicable settlement. If no agreement is reached, the dispute shall be resolved through court or arbitration, and during this period, the Exchange shall not transfer the collateral to either party.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам
Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities



- 3.15. Хэрэв Биржийн цахим арилжааны ялагч нь энэхүү журмын 3.5.2-т заасан үүргийг биелүүлээгүй, биелүүлэхээс зайлсхийсэн тохиолдолд энэхүү журмын 3.14 дэх заалт хамаарахгүй.
- 3.15. If the winning bidder of the Exchange's electronic trading fails or avoids fulfilling the obligation stated in Clause 3.5.2, then Clause 3.14 shall not apply.
- 3.16. Худалдан авагч нь дэнчингийн үлдэгдлийг Биржтэй хагас жил, жил тутамд тулган баталгаажуулалт хийнэ.
- 3.16. The bidder shall conduct a semi-annual or annual reconciliation with the Exchange to verify any remaining collateral balance.

ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ **FOUR. TRADING FEE**

- 4.1. Бирж нь бүртгэх үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийн нэхэмжлэхийг худалдагч, худалдан авагчид илгээнэ.
- 4.1. The Exchange shall send the invoices for registration service fees and trading fee to both the seller and the bidder.
- 4.2. Тухайн арилжаанд худалдан авагчаар шалгарсан этгээд нь энэхүү Журмын 4.1-т заасан нэхэмжлэх хүлээж авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 4.2. The bidder selected in the respective trade shall transfer the amount specified in the invoice referenced in Clause 4.1 to the Exchange's account within 3 working days of receiving the invoice.
- 4.3. Худалдагч нь бүртгэх үйлчилгээний хөлсийг худалдах захиалга бүртгэгдэн нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд шилжүүлнэ.
- 4.3. The seller shall transfer the registration service fee to the Exchange's account within 3 working days after the sell order is registered and the invoice is received.

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА **FIVE. RISK MANAGEMENT**

- 5.1. Бирж нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан худалдагч эсхүл худалдан авагчаас форвард гэрээний арилжаанд хязгаар тогтоох, дэнчингийн хэмжээг журамд зааснаар нэмэгдүүлэхийг шаардаж болно.
- 5.1. The Exchange can require the seller or bidder to impose limits on forward contract trading or to increase the amount of collateral in accordance with market conditions as stipulated in this Regulation.
- 5.2. Худалдагч эсхүл худалдан авагч нь Журмын 5.1-т заасны дагуу нэмэлт дэнчинг цаг тухайд нь байршуулаагүй, эсхүл бусад зөрчил гаргасан тохиолдолд Бирж нь тухайн худалдан авагчийн арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.2. If the seller or bidder fails to deposit the additional collateral on time as required under Clause 5.1, or violates other provisions, the Exchange shall take measures to restrict the bidder's right to participate in trading.

---oOo---

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам
Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities

“Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны төлбөр
тооцооны журмын Хавсралт 1.
Annex 1 of “Regulation On Exchange Trade
Settlement Of The Mineral Commodities”

**Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэл, үйлчилгээний хөлсний ерөнхий
нөхцөл**

General Provisions on Mineral Commodities Trading Fee and Service Charges

Шимтгэл, үйлчилгээний хөлс төлөх этгээд Entity Responsible for Paying the Fee and Service Charge	Зуучлагчгүй гэрээ Without Broker	Зуучлагчтай гэрээ With Broker
Худалдагч талын бүртгэх үйлчилгээний хөлс төлөх хэмжээ Seller's Registration Service Fee amount	1 багц 100,000 төгрөг 100,000 MNT per 1 lot	
Худалдан авагч талын арилжааны шимтгэл төлөх Хэмжээ Buyer's Trading Fee amount	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.1 хувь 0.1% of the total Implied agreement value	Тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.08 хувь 0.08% of the total Implied agreement value

---o0o---

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам
Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities

Dynamic translation center
Tel: 976-95904858
Email: dynamictranslation123@gmail.com



Хуудас 7